

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код:73.040

Сайжруулсан хатуу түлш. Техникийн шаардлага	MNS 5679 : 2014
Upgraded solid fuel. Technical requirements	MNS 5679:2014–ийн оронд

Стандарт, хэмжил зүйн газрын ...оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... тоот тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2019 оны 05 дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Нүүрсэн шахмал түлш, хагас коксон шахмал түлш, модны үртсэн шахмал түлш, эдгээрийн нэгдлээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн/цаашид “сайжруулсан хатуу түлш” гэх/-д хамаарна.

Энэхүү стандартаар сайжруулсан хатуу түлшний техникийн шаардлагыг тогтооно.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах дараах эш татсан стандарт баримт бичгүүдийг хэрэглэнэ. Хугацаа заагаагүй стандартын хувьд сүүлчийн хувилбарыг ашиглана.

1) ISO 1213 Solid mineral fuels – Vocabulary

- Part 1: Terms relating to coal preparation,
- Part 2: Terms relating to sampling testing and analysis.

2) MNS 1744 Хатуу түлш. Шинжлэх үзүүлэлтийн тэмдэглэл, янз бүрийн төлөвтэй түлшний шинжилгээний үр дүнг шилжүүлэн тооцох томъёо

3) MNS 6457 Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал

3 Нэр томъёо, тодорхойлолт

3.1

сайжруулсан хатуу түлш

физик болон механикийн үйлчлэлийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг хэлнэ.

3.2

нүүрсэн шахмал түлш

бүх төрлийн нүүрсний нунтагийг холбогчтой, эсвэл холбогчгүй шахаж хийсэн түлш.

3.3

MNS 5679:2019 ТӨСӨЛ /2019-04-19/

хагас коксон шахмал түлш

нүүрсний хагас коксын нунтагийг холбогч материал ашиглан шахаж хийсэн түлш.

3.4

модны үртсэн шахмал түлш

модны үртсийг өндөр даралт, температурт шахаж хийсэн түлш.

3.5

(W^{ar}) %

дээжийг хүлээж аваад тодорхойлсон нийт чийглэгийн хэмжээ, % (W-water буюу ус, ar - as received буюу хүлээн авснаар)

3.6

(S^d_t) %

нийт хүхрийг тодорхойлоод, хуурай төлөвт (d-dry буюу хуурай) нь тооцсон хэмжээ, %

3.7

(V^d) %

дэгдэмхий бодисыг тодорхойлоод, хуурай төлөвт тооцсон хэмжээ, %

3.8

A^d %^б

дээжний үнсийг тодорхойлоод, хуурай төлөвт нь тооцсон хэмжээ, %

3.9

(Q^{ar}_{net})

түлшийг шатаахад гарах тодорхойлсон илчлэгийг доод хэмжээгээр нь тооцсон хэмжээ, ккал/кг

4 Техникийн шаардлага

4.1 Сайжруулсан хатуу түлшний техникийн шаардлага 1-р хүснэгтэд заасантай тохирч байна.

4.2 Сайжруулсан хатуу түлш нь хэрэглэх зориулалтаас шалтгаалж төрөл бүрийн хэлбэр, хэмжээтэй байж болно.

4.3 Хэрэглэгчдэд нийлүүлэх бүтээгдэхүүн нь хадгалалт, тээвэрлэлтийн явцад анхны хэлбэр, хэмжээ нь алдагдаж, амархан бутрахгүй байх шаардлагыг хангана. Бүтээгдэхүүний анхны хэлбэр болох гадаргуугийн овор хэмжээ нь 30% -иас ихээр эвдэрч өөрчлөгдсөнийг “бутармаг” гэж үзээд нийт жингийн 5%-иас хэтрэхгүй байна.

1-р хүснэгт

№	Түлшний төрөл	Нийт чийглэг (W ^{ar}) %, ихгүй	Нийт хүхэр (S ^{ar}) %, ихгүй	Дэгдэмхий бодис (V ^o) %, ихгүй байна.	Үнслэг A ^d %, ихгүй	Доод илчлэг (Q _{net} ^{ar}) (ккал/кг) багагүй	Бат бөх %, багагүй (унагах аргаар)
1	Нүүрсэн шахмал түлш	10	1,0	22	28	4200	80
2	Хагас коксон шахмал түлш	10	1,0	22	30	4500	85
3	Модны үртсэн шахмал түлш	10	-	-	5	4000	80

5 Шалгах, хүлээн авах, турших арга

5.1 Сайжруулсан хатуу түлшийг хэрэглэгчид нийлүүлэхдээ энэ стандарт, MNS 0894 : 2001 “Хүрэн ба чулуун нүүрс, антрацит, шатах занар, шахмал түлш - Хүлээн авах журам” стандарт, түүнд нийцүүлэн гаргасан “Байгууллагын стандарт”-ын баримтлана.

5.2 Сайжруулсан хатуу түлшнээс дээж авах, шинжилгээ хийхдээ дор дурсан стандартуудыг мөрдөх буюу шинжилгээнд тохирох бусад олон улс, бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, холбогдох бусад арга аргачлалыг хэрэглэж болно. Үүнд:

- 1) MNS 2732 Хүрэн, чулуун нүүрс, антрацит, шатах занар. Ашиглалтын дээж авах арга
- 2) MNS 0655 Хүрэн, чулуун нүүрс, антрацит, шатах занар. Чийглэг тодорхойлох арга
- 3) MNS 4057 Хатуу түлш. Чийгийг тодорхойлох хурдавчилсан арга
- 4) MNS ISO 589 Чулуун нүүрс. Нийт чийгийг тодорхойлох
- 5) MNS ISO 11722 Хатуу эрдэс түлш. чулуун нүүрс. Ерөнхий шинжилгээний туршилтын дээжин дэх чийгийг азотаар хатааж тодорхойлох
- 6) MNS 3903 Хатуу түлш. Хүхэр тодорхойлох арга.
- 7) MNS ISO 157 Нүүрс. Хүхрийн хэлбэрийг тодорхойлох

MNS 5679:2019 ТӨСӨЛ /2019-04-19/

- 8) MNS ISO 351 Хатуу эрдэс түлш. Хүхрийн ерөнхий хэмжээг тодорхойлох. Өндөр температурт шатаах арга
- 9) MNS ISO 562 Чулуун нүүрс ба кокс. Дэгдэмхий бодисын гарцыг тодорхойлох
- 10) MNS 0652 Хүрэн чулуун нүүрс, антрацит, шатах занар. Үнслэг тодорхойлох арга
- 11) MNS 5675 Нүүрсний илчлэг тодорхойлох түргэвчилсэн арга
- 12) MNS ISO 1928 Хатуу эрдэс түлшний илчлэгийн нийт утгыг бортогон калориметрийн аргаар тодорхойлох ба илчлэгийн цэвэр утгыг тооцоолох арга
- 13) MNS ASTM D 440 Хүрэн, чулуун нүүрс болон антрацит. Уналтын бат бэхийг тодорхойлох стандарт арга
- 14) MNS 0893 : 2001 Хүрэн, чулуун нүүрс, антрацит, шатах занар. Үзэгдэх чулуулаг ба жижгэрсэн ширхгийн агуулгыг тодорхойлох хяналтын дээжийг турших арга
- 15)

5.3 Сайжруулсан хатуу түлшний бат бөхийг тодорхойлохдоо “**чөлөөт** уналт”-ын аргыг хэрэглэнэ. Бүтээгдэхүүнээс таваас зургаан ширхэг дээжийг сонгон авч 1,83 метрийн өндөрөөс эгц доош чулуун болон хатуу **гадаргуу** дээр унагаана. Унасан дээжийн **бутармаг** хэсгийг цуглуулан хэмжиж анхны түлштэй харьцуулж бат бөхийн хэмжээг тооцоолох ба 1-р хүснэгтэд заасан хэмжээтэй харьцуулах аргаар шаардлага хангаж байгаа эсэхийг тодорхойлно.

5.4 Сайжруулсан хатуу түлшний үнс нь гадны ямарваа нэг хүч үзүүлээгүй байхад анхны түлшний хэлбэрээ хадгалж байвал зохино.

6 Хадгалах, шошго хэрэглэх

6.1 Зориулалтын агуулахад хадгална.

6.2 Сайжруулсан хатуу түлшний сав, баглаа, боодол дээр дараах агуулга бүхий хэвлэмэл хаяг наасан байна. Үүнд:

- Улс, хот, аймгийн нэр;
- Үйлдвэрийн нэр, **холбоо барих утас, интернет, шуудангийн хаяг;**
- Бүтээгдэхүүний нэр;
- Жин (кг);
- Үйлдвэрлэсэн огноо;
- **Савласан огноо;**
- Энэ стандартын дугаар;
- **Тээвэрлэлт;**

- Хадгалах, хэрэглэх зааварчилгаа

ТӨГСӨВ.